

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сүхээ	Дугаар	L148
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Бөмбөгөр
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Малчин		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Чойниг, Дашгалдан	Сүм хийдийн дугаар	БХБР 070, БХБР 075
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 11	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Чойниг болон Дашгалдан хийд

Асуулт:-Ингээд Сүхээ гуайгаас тус сумын нутагт Өлзийт голын захад байсан **Чойниг** хийдийн талаар асууя.

Хариулт:-Тэр хийдийн суурь л байдаг юм. Энд сүүлийн үеийн 67 он хүртэл байна уу даа, могой Даваа гэдэг өндөр тахир өвгөн байсан. Тэднийх байнга тэр хийдийн уг сэрвээн дээр нь, уг нь туйлуу, чулуугаар барьж байсан хийдийн суурь л байдаг юм. Тэр явсаар байгаад одоо ч зэргэлдээ нэг бууцтай, хавар болохоор хойд талын **Бууцагааныхан**, заримдаа **Бөмбөгөрийнхөн** очоод нутаглаад байдаг юм л нэг суурь балгасын суурь байдаг юм.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй. Цөөхөн ламтай байсан гэж дуулсан.

Асуулт:-Тийм нэртэй лам байсан?

Хариулт:-Тэрнийг мэдэхгүй.

Асуулт:-Тахилга уулын сүмийн талаар мэдэх үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тахилга уул бол Бөмбөгөр сумын хуучин 8-р баг гэж байсны нутагт байдаг нутаг байгаа. Тэрний тахилга уул бол олон талаасаа хөл улс ихтэй, нутгийн ард түмэн их шүтэж явдаг, жилд 1 удаа, хавар зуны сар гарав уу, үгүй юу тэгээд тахичихдаг тийм л уул байсан юм. Ан гөрөө ихтэй ийм л сайхан нутаг байсан. Төрөл бүрийн ургамал бичээстэй, амьтан хүмүүс айл нутаглаж их ашигладаг байсан.

Асуулт:-Тэр хийдийг бүрэн бүтэн байхад нь та харж байсан үү?

Хариулт:-Үзсэн. Дашгалдан хийдийн чинь дэргэд манай өвгөн аав бид нар нэг дороо амьдарч,тэр хийдийг сахиж, эргэж тойрдог байсан юм, миний өвгөн аав.

Асуулт:-Тахилга уулын сүмийг?

Хариулт:-Тахиж барихад тэр улс амьтанд зарлага хийх юмнууд нааш цааш нь зохион байгуулдаг, манайд нэлээн нэртэй өвгөн аав байсан.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-7 лам байсан. 7 ламаас сүүлдээ явсаар байгаад 3 лам үлдсэн санагдаж байна. 2-ыг нь тодорхой сайн мэдэж байна. Шарын Содном гэдэг нэг лам байсан. Вандангийн Дэмбэрэл гэж лам. Вандангийн Найдан гэж Дэмбэрэлийн ах нь байсан юм. Ах дүү 3 лам байсан юм. Дүү нь Жадамба гэж байж байгаад хүрээ хийдэд суудаггүй байсан юм, хааяа нэг ирж очдог муухан мэддэг юм би, жаахан хүүхэд байсан үе шүү дээ. Сүүлийн үед Жадамбынх нүүгээд **Уушгийн** хадны нуруугаар тэр тахилгаас чинь нүүгээд 5-р багийн нутагт очсон юм. Хамгийн сүүлд явсаар байгаад миний эхтэй холбогдож байсан Дэмбэрэл тэр хийдийн эзэн хоцорсон. Бусад нь ийш тийшээ. Содном гуай бол биеэ даагаад тусдаа гараад явчихсан. Миний эцэг Вандангийн Дэмбэрэлийг баригдаад явсны дараагаар Шарын Содном гэдэг хөгшин лам баригдаж байсан юм. Тэр баригдаж яваад Архангайд байсаар байгаад зусаад, намаржаад, өвлийн эхэн сарын зул сарын 25-нд буцаж ирж нутагтаа тэгж ирж байсан. Тэгээд насалсаар байгаад 83, 84 хүрээд нас барсан. Нутагтаа байж байгаад.

Асуулт:-Тэр хийд 7 ламтай, жижиг хүүхдүүд шавилж байсан үү?

Хариулт:-Шавилж байсан.

Асуулт:-Хэд орчим хүүхэд байсан юм бол?

Хариулт:-4 хүүхэд л суудаг байсан юм.

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол, тэр хийдийн?

Хариулт:-Гол шүтээн нь ирэхгүй нутаг орны хүн гэж байхгүй, нутаг орныхон болохоор ялангуяа намрын **Майдар** эргэхийг угтуулж их л улс амьтан ирдэг ийм л газар байсан. Газар нь хадан дотор болохоос биш уг барилга бол... Би муухан санадаг юм. Хархорины Эрдэнэзуугийн хийдийнх шиг тийм хөөрхөн дуган байсан юм. 1938 оны зун миний эцгийг бариад явчихсан.

Асуулт:-Ямархуу хүмүүс ирээд барьсан бэ?

Хариулт:-Би тэгэхэд Хотын булан гэдэг **Уушгийн** хадны чинь ар хормойд тэмээ хариулаад явж байтал барих юм гэнэ лээ гэж дуулдаж байсан юм.

Асуулт:-Танай аав тэр хийдийн лам хүн байсан юмуу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Лам байсан.

Асуулт:-Ямар цолтой хүн байв?

Хариулт:-**Гэсгүй** цолтой байсан юм. Тэгээд барих юм гэлээ гэж **дуулчихаад** манай аав хоол унд идээд, хонож өнжөөд, тэгээд хийд дээр сууж байдаг тийм хүн байсан байхгүй юу. Тэгээд тэр хотын буланд аваачаад тэмээгээ хужирт **оруулчихаад** тэр зуны манай эцэг маань тэрүүхэнд бүүчихдаг юм. Барих юм гэнэ лээ гэж дуулсан юм. Тэгсэн чинь айлд **ирчихээд** хярам **уучихаад** сууж байсан чинь энэ урд руу хөтөлгөө морьтой хүн орж ирж байгаа юм. Тэгэхэд эцэг гэртээ байхгүй. Гэрээсээ гарч хийд рүү явсан. Тэгсэн чинь нэлээн зайдуухан шиг энэ **ирмэгний** хэрээтэй газар **ирчихээд мориноосоо бүүчихаад** танай айлын хүн хаачсан, хэн гэдэг юм гээд. Би бага хүүхэд 11-тэй юмуу, 12-той байсан юм шиг байгаа юм.

Асуулт:-1932 онд уу?

Хариулт:-1938 онд. Тэгээд тэр айл нь хазгар Ням гэдэг айл байсан юм. Тэдний хоёр хүүхэд, одоо хоёулаа амьд сэрүүн байж байгаа, Бямбажав гэдэг эмээ байна, Хоньч гэдэг өвөө байна. Тэр хоёр жаахан хүүхэд намайг дагаад, Бямбажав нь овоо том болсон, хамгийн том эгч нь. Тэр Хоньч нь жаахан юм байсан. Бид гурав яваад.. морио тушчихаад ойртож ирээд тамхи татаад суусан, нөгөө барих гэж ирсэн хүн чинь. Тэгж байтал манай аав чинь тэр дээшээ Элстэй ам гэдгийн тэр лүү, цайвар цагаан морьтой байсан. Хүрээд ирж байсан. Лам дээлтэйгээ яваа. Хаа хүрээд ирэв, хаачаад ирэв гээд шалаад, танайх хэн гэдэг хүн бэ гэж нэрийг нь асуугаад Дэмбэрэл л гээд байсан. Гэрээ онгойлго, гэр чинь алив гэсэн. Нэг жаахан жижиг гэртэй байсан юм. Онгойлгуулаад орсон чинь хоёр улаан эрээн авдар чинь жаахан хөөрхөн юм байсан шүү дээ. Тэрнийг нь онгойлгуулаад доторх юмыг нь онгичиж үзэж хараад, тэгээд аваачиж цаас наагаад тэгээд лацдаж байгаа юм шиг цаас **наачихаж** байсан юм. За морь сайн уу гэж байна. Гайгүй гэж байгаа **болтой**.

Тэгээд аваад туугаад гарсан. Бид гурав ч **зугатаагаад** тэр доод руу яваад өгсөн. Тэгээд тэр Хоньч, Бямбажав хоёрын эцэг нь барих юм гэж **дуулчихаад**, айгаад хол явчихсан. Тэгээд тэр хоёр хүүхэдтэй цаашаа уруудаад явж байсан чинь **манай** өвгөн аав тэр доор, тэмээ хариулсан хүнтэйгээ явж байна, чи муу нохой энд юу хийж яваа юм гээд намайг чинь зуны халуун наранд чинь. маргааш нь аваачаад ламд барих юм гэж дуулаад эцгийг барихыг **дуулчихаад** зуны лагерийнх нь гэрээр нь аваачаад хийгээд тавьчихсан. Би урд өдөр нь тэмээ хариулсан өдрөө ирж юм **уучихаад явчихаж байгаа** юм. Тэгээд тэр доод талын чинь уртын булангийн **Уушгийн** хадны хойд үзүүрээр чинь Хэцүү хоргой гэдэг уулаар хөөгөөд намайг түүчихлаа шүү. Манай аав чинь явган хөөгдөөд, явсаар байгаад ийшээ одоо хийд байсны чинь хойд орой дээр манайхан **зүсч** байсан юм. Шар толгой Пүрэвжав гэж нэг өвгөн, Бямбын Готов гэж мужаан, Пүрэвжав гуайн хүргэн нь байсан. Манайхан айл байсан юм. Манайхны байгаагийн баруун тал дээр Өндөр хүрэн гэж уул байгаа юм, тэрний **өврөөд** ингэж доороос өгсөж байгаад гүйгээд ядарч байгаа гэж, тэр хооронд 11, 12 км байсан байх. Энэ **уулаад гарчихаар** аав яадаг юм гэж бодоод **уулаад** авираад **бэлээд** нь гараад явчихсан. Чи муу нохой хаачих гэсэн юм шав шув гэсэн чинь энэ дундуур ташуур нь ороогоод хамраас цус гоожоод цаашаа эргэж бүүж, газрын уруу ч байсан юм, гүйж шогшоор байгаад гаднаа очоод гэрийн сүүдэрт **суучихаад**, гадаад ус байсан юм. Уснаас цусаа **угаачихаад**

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэгээд байж байсан чинь өнөө муу эцгийг чинь туугаад нөгөө Элст гэдгийг чинь өгсөж, манай хажуугаар туугаад гараад хийд рүү орлоо.

Асуулт:-Тэр тууж байгаа хүн нь танай нутгийн хүн үү?

Хариулт:-Манай сумын намын үүрийн дарга байсан Даринчулуун гэдэг хүн байсан юм байна лээ. Би сүүлд нь сураглаад байсан чинь.

Асуулт:-Тэгээд ганцхан хүн л аваад **явчихаж** байгаа юмуу?

Хариулт:-Ганцхан хүн аваад **явчихаж** байгаа юм. Сум буу үүрсэн. Тэгээд аваад **явчихаж** байсан юм. Тэгээд манай айлынхан хөөе Сүхээ тэр хонь явлаа гээд, саалиа саагаад **дуусч** байгаа, салхи сөрөөд зүүн тийшээ гарах гэж байсан. Хонь буцааж ус руу оруул гээд. Сайхан далим гарлаа гэж бодоод хонийг нь эргүүлж хийдийнх нь баруун талын задгай руу аваачиж **оруулчихаад** хийд дээр гүйгээд очсон чинь дөнгөж дуганаа онгойлгоод орж байна. Тэгээд хараад явж байсан чинь нэг их том цөгцтэй зул өргөчихсөн байсан юм байна. Тэгсэн чинь хоёр **зулы** нь аваачиж үлээгээд, нөгөө барьж авсан хүн чинь. Тэгээд 4 сайхан тасалгаа өрөө байсан юм, **цугааранд** нь орж байгаа юм. Хоёр сайхан бүрээ бишгүүртэй, 4 сайхан хэнгэрэгтэй, тэгээд ер нь шашны эдлэл хэрэглэлүүд овоо л юм байсан юм.

Асуулт:-Ганжуур, **Данжуур** гээд олон том судрууд байдаг шүү дээ.

Хариулт:-Тэгээд би яах нь вэ гээд дагаж харж байсан чинь тэр хүрээнүүдээр **орчихоод** тэр барих гэж яваа хүн чинь сандрах ч үгүй юм. Тэгээд би чинь гараад доошоо хониныхоо ар талыг услах гээд явж байсан чинь хийдийг чинь **хаачихаад цоожлоод** хөндлөнгөөр нь дээгүүр, доогуур нь уртаашаа цаас **наачихаад** яваад өгсөн. Тэгээд орж болохгүй гээд. Тэгээд аваачиж танайхан байгаа юм, хийдийн юмнууд сайн харж барьж байгаарай, 2, 3 хоноод ирээд энэ дуганыг буулгана гээд явсан байдаг юм.

Асуулт:-Үүсгэсэн хүний нэр алдрыг мэдэхгүй юу?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Монголчууд өөрсдөө барьсан уу?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Хийдийн лам нарыг овоо тахиж байхыг нь мэдэх үү? яаж тахидаг байсан юм бол?

Хариулт:-Хийдийн лам нар очоод ном уншдаг байсан. Хийдийн чинь хажууд талын ууланд махгүй л овоо тахидаг байсан юм гэнэ лээ, дандаа цагаан идээгээр.

Асуулт:-Бөх барилдах уу, морь уралдах уу?

Хариулт:-Барилдахгүй. Тахидаг ууландаа тэрүүхэн орчимдоо дамжиж гараад очдог болохоос биш морь уралдах, бөх барилдах талбай байхгүй.

Асуулт:-Цам **Майдар** гардаг байсан уу?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Ямар урсгал байсан юм бол, улааных уу, шарынх уу?

Хариулт:-Шарынх

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Эмэгтэй лам байсан уу?

Хариулт:-байхгүй.

Асуулт:-Том нэртэй, хутагт хувилгаад, лам нар байсан уу?

Хариулт:-байхгүй.

Асуулт:-Номоо хэвлэдэг модон бар байсан болов уу?

Хариулт:-Том зэс тогоо байдаг байсан. Тэр зэс тогоо нь явсаар байгаад суманд нэг үзэсгэлэнд тавьчихсан байсан, музейд тэр байдаг юмуу, үгүй юмуу мэдэхгүй.

Асуулт:-Сүмийн жас, мал **хуйгий** нь мэдэх үү? Хэд орчим малтай, яаж маллаж хариулдаг байсан юм бол?

Хариулт:-Хийдийн чинь лам, ах дүү нар нь тэр Найдан гэдэг чинь баригдаж явахаас өмнө нас барчихсан юм, тэр лам чинь, настай хүн байсан. Би тэр Найданг өөрийнхөө эцэгтэй л мэдэж байгаа юм. Тэрнээс Жадамбаа бол ирэн очин, бага шиг залуу байсан. Намайг 1939 оны намар сургуульд явахад тэр Жадамбын чинь нэг **хүү Александр** гэж ганц хүүтэй тийм айл байсан юм. Авгай Шоонд гэдэг хүн байсан юм гэнэ лээ. Би тэрнийг мэдэхгүй юм. Тэгээд тэр **Александр** гэж явсаар байгаад миний тэр эцгийн бичиг баримтыг уг нь энэ сумынх нь Дэмбэрэл нэртэй хүн хоёр явж байсан юм билээ.

Асуулт:-37 оны яг хэдэн сарын **хэдэнд** баригдсан гэнээ?

Хариулт:-38 оны 5 сарын 25-ны үе шиг санагддаг юм.

Асуулт:-Тэгээд таны эцгийг бариад аваад явсан?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Цаазаар авсан уу?

Хариулт:-Тийм, цаазаар авсан байдаг юм. Би тэр лам эцгээсээ хоёулаа хоцорсон юм. Ээжтэйгээ, ээжийн ах, манай өвгөн аав ийм ам бүлтэй байсан улсууд. Миний тэр эмэгтэй дүү 1984 онд нас барсан.

Асуулт:-Тахилга уулын сүмийг дараа нь яасан бэ? нураасан уу? Бурхан шүтээн нь яасан юм бол?

Хариулт:-Тэр хийдийг чинь дараа нь 3 хоносны дараагаар би өглөө босоод байж байсан чинь гадаа юм нүдээд, тог тог гээд чимээ гараад байх юм, тэгсэн чинь юу байдаг юм бол гээд энэ хойд тал дээр дөрвөлжин бунхан байсан юм.

Асуулт:-Тэр бунхан гэдэг нь ямар учиртай юм бол?

Хариулт:-Тэр дотор нь хүрээ хийдийн чинь хийсэн байсан улсууд жаахан юм аваачиж залдаг, зул өргөдөг тийм жаахан хөөрхөн дөрвөлжин юм л байсан.

Асуулт:-Идээнийхээ дээжийг тавьдаг, зул өргөдөг?

Хариулт:-Тийм л юм байсан.

Асуулт:-Модоор барьсан байсан уу?

Хариулт:-Тэр дан чулуугаар. Тэгээд чимээ гараад байхаар хүрээд ирсэн чинь орой дээр нь 3 хүн гарчихсан буулгаж байна. Тал талдаа арслан хийчихсэн, янз бүрийн юмнууд хийсэн их гоё хөөрхөн дуган байсан юм.

Асуулт:-Дээрээ ганжиртай байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Байсан. **Нөгөөдөхийг** нь устгаад. Тэгээд дотор нь байсан ном, судар бүх юмнуудыг чинь тэр эрэг рүү аваачиж шатаасан байдаг юм. Зэс **гуулин** юмыг нь аваад **явчихаж** байсан байхаа. Бурхан номыг нь шатаагаад, тэгээд тэр муу **байшингий** нь буулгаад.

Асуулт:-Дээвэр нь мод байсан уу?

Хариулт:-Дээвэр нь сайхан мод байсан. Модыг нь суманд зөөж авчраад юм хийсэн юмнууд байж л байдаг юм.

Асуулт:-Сургууль, эмнэлэг барьсан уу?

Хариулт:-Сургууль, эмнэлэг, худалдааны анги тэнд юм хийгдэж байсан. Модыг нь сайхан ашиглаж байсан, их сайхан цагаан моднууд байдаг байсан.

Асуулт:-Ямар хэмжээтэй дуган байсан юм бол, хэд хэдийн харьцаатай дуган байсан юм бол?

Хариулт:-8-аас 10 харьцаатай байсан байх. Дотроо 4 тасалгаа байсан шүү. Одоо тэр дуган минь байсан бол тэнд чинь нэг багийн сайхан контор, гол заалаар нь соёл урлагийн юм явуулж болох, тэмцээн, юм юм явж байхад чөлөөтэй, 4 өрөөнд нь хүн амьтан суучихна, 2 өрөө болгочих юмуу, тэгээд ашигласан бол сайхан барилга байсан.

Асуулт:-Тэр үед хятадын наймаачид, худалдаачид байсан уу?

Хариулт:-Байхгүй

Асуулт:-Пүүс байгаагүй юу?

Хариулт:-Байгаагүй. Хятад манайд чинь хамгийн сүүлд Хуваа гэдэг хятад байж байгаад 2-р багт гэр бүлтэй болчихсон, 2, 3 хүүхэдтэй, ногоо зөөлгөж идсэн тийм хятад байдаг байсан.70 нэлээн гараад 80 шахаад нас барсан.

Асуулт:-Лам нарын хоол ундыг нь бэлддэг байсан тогооч эд нарыг нь мэдэх үү?

Хариулт:-Мэдэхгүй.Голдуу л манайхаар идэж уудаг байсан юм.

Асуулт:-Цөөхөн ламтай болохоор тэгдэг байсан байх даа

Хариулт:-Тийм.